



**ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧИЙН
ГАРЫН АВЛАГА**




**БАНКАНД САНХҮҮГИЙН
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2022

АГУУЛГА



1. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
2. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭМЖЭЭГ ХЭРХЭН ТООЦОХ ВЭ?
3. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ
4. АКТИВ, ПАССИВЫГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ БАНКИЙГ СОНГОХ
5. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА
6. АКТИВ, ПАССИВЫГ ШИЛЖҮҮЛЭН АВСАН БАНКААР ҮЙЛЧЛҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ
7. ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТ





1. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Санхүүгийн дэмжлэг гэж “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль” -ийн 3.1.8 -д заасны дагуу банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив пассивыг шилжүүлэн авч байгаа банкинд актив, пассивын зөрүүг нөхөх, эсхүл тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөнд хөрөнгө оруулахыг хэлнэ.



ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ ГИШҮҮН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДОГОЛДСОН ТОХИОЛДОЛД БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН БОЛГОХ ЗОРИЛГООР ДЭЭРХ 2 АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ШААРДЛАГАТАЙ МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ЮМ.


2. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭМЖЭЭГ ХЭРХЭН ТООЦОХ ВЭ?

Актив, пассивын зөрүүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үед:

Банк төлбөрийн чадваргүй болсон эсхүл үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн банкны даатгагдсан хадгаламжийг үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа өөр банк руу шилжүүлдэг. Ингэхдээ тус хүндрэлд орсон банкны сайн актив хөрөнгийг нийт даатгагдсан хадгаламжийн хамтаар шилжүүлэх бөгөөд тус шилжүүлгийн явцад үүсэх зөрүүг хадгаламжийн даатгалын сангаас гаргана.

Тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах үед:

Тусгай зориулалтын банк гэдэг нь Монголбанкны шийдвэрийн дагуу хүндрэлд орсон банкны үйл ажиллагааг хэвийн болгох зорилгоор түр хугацаатайгаар байгуулагдан, тус банкны актив, пассивыг шилжүүлэн авч ажиллах банкиг хэлнэ. Хүлээн авсан хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын дүнд үндэслэн тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөнд хөрөнгө оруулж, санхүүгийн дэмжлэгийг үзүүлнэ. Корпорацийн хувьд Тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгийн хэмжээний 33 хувиас хэтрэхгүй хувьд хөрөнгө оруулах зарчмыг баримтална.





3. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ

Монголбанкнаас банканд
бүтцийн өөрчлөлтийн
арга хэмжээг авч
хэрэгжүүлэх шийдвэр
гаргана

1

- ХДК болон Сангийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ
- Тусгай төлөөлөгч томилно

Монголбанкнаас бүтцийн
өөрчлөлтийн аль арга
хэрэгслийг ашиглахыг
шийдвэрлэнэ

2

- Актив, пассивыг шилжүүлэх
- Тусгай зориулалтын банк байгуулах

Хадгаламжийн даатгалын
Үндэсний хороогоор
банканд үзүүлэх
санхүүгийн дэмжлэгийн
хэлбэр, хэмжээг батлуулж,
шийдвэрлүүлнэ

3

- Санхүүгийн дэмжлэгийн эцсийн тооцоолол, зардлын харьцуулалт, мөнгөжүүлэх төлөвлөгөө болон бусад холбогдох материалуудыг танилцуулна.

Монголбанкнаас гаргасан
шийдвэрийн дагуу ХДК-ас
санхүүгийн дэмжлэгийн
шилжүүлгийг гүйцэтгэнэ

4

- ХДК-с санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдэгдэл хийнэ
- Санхүүгийн дэмжлэг хүлээн авч байгаа банктай гэрээ байгуулна


4. АКТИВ, ПАССИВЫГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ БАНКИЙГ СОНГОХ

Актив, пассивыг шилжүүлэн авах банкныг Монголбанкнаас сонгож, шийдвэрлэдэг. Корпорацийн хувьд “Банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д заасны дагуу банк нь мөнгөн хадгаламж татах тусгай зөвшөөрөл, зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байгаа эсэх, Монголбанкнаас хийгдсэн шалгалтын үнэлгээ, үүрэг даалгаврын биелэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьдаг.

5. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА


Хүндрэлд орсон банкны актив пассивыг шилжүүлэхдээ тус банкны үйл ажиллагааг зогсоон тухай долоо хоногийн сүүлийн ажлын өдөр шилжүүлгийг гүйцэтгэж, шинэ долоо хоног эхлэхэд банкны үйл ажиллагааг нээнэ.

Үүнээс хойш харилцагч, хадгаламж эзэмшигчид банкны салбар, нэгжүүдээрхэвийн үйлчлүүлэх боломжтой болох бөгөөд актив, пассивыг шилжүүлэн авч буй банкны салбар нэгж дээр өөрийн баримт бичигтэй очиж үйлчлүүлэх боломжтой.



6. АКТИВ ПАССИВЫГ ШИЛЖҮҮЛЭН АВСАН БАНКААР ҮЙЛЧЛҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Хүндрэлд орсон банкны салбар нэгж болон харилцагчдын мэдээлэл хүлээн авч буй банк руу шилжсэн байх тул бүх салбар нэгжүүдээр өмнө авч байсан үйлчилгээг хэвийн авах боломжтой хэдий ч харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээг шинэчлэн байгуулах шаардлагатай.



Харилцагчийн хүсэлтээр шинэ банкны нэрээр баримт бичгийг өөрчилж болох бөгөөд шинээр баримт бичиг бүрдүүлэх шаардлагагүй

7. ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТ

1. Гомдол хүлээн авах

- ХДК иргэдийг хүлээн авах танхим
- Сонгогдсон банкны салбарууд
 - БЭХА

2. Гомдол шийдвэрлэх

- ХДК
- БЭХА

3. Шийдвэрийг мэдэгдэх

- ХДК
- Сонгогдсон банк

